



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар A/127

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Бүрд, Баян-Өндөр, Есөн-Зүйл, Өлзийт сумдын нутгаар 2018-2019 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх нөхцөл байдал үүссэн тул Булган аймгийн Рашаант, Дашинчилэн, Төв аймгийн Эрдэнэсант, Дэлгэрхаан сумдад оторлож байгаа малчдын төрийн үйлчилгээний зардалд зориулж Дашинчилэн суманд 2000000 (хоёр сая) төгрөг, Рашаант суманд 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, Эрдэнэсант суманд 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээний зардал нийт 5000000 (таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100282